

ТАНИЛЦУУЛГА

Журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан тухай

Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгоход баримт бичгийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд тусган зохицуулсан бөгөөд мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журмыг нийгмийн даатгалын төв байгууллага тогтооно” гэж заасан.

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалаар “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ыг батлан, мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална” гэж заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, журмын төслийг тус тус боловсруулав.

Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг тэтгэврийн төрөл тус бүрээр нь ангилан тусгасан бөгөөд даатгуулагч зөвхөн өөрт шаардлагатай баримт бичгийг цахимаар эсхүл цаасаар бүрдүүлэх юм.

Мөн нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, өөрийн архивт байгаа мэдээллийг даатгуулагчаас шаардахгүй, түүнчлэн төрийн мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан бусад холбогдох мэдээллийг татахаар журмын төсөлд тусгасан.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож олгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна” гэж заасны дагуу цэргийн алба хаагч нь цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийг мөн тусгасан болно.

Мөн журмын төслийг боловсруулахдаа Процессийн дахин инженерчлэлийн ажлын хүрээнд гарсан саналыг тусгалаа. Тухайлбал:

-нийгмийн даатгалын байгууллага өөрт байгаа мэдээллийг иргэдээс шаардахгүй;

-иргэд баримт бичгийг цахимаар ирүүлж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхээр;

-иргэдийн бүрдүүлэх баримт бичгийн тоог 13-аар цөөрүүлсэн.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ